



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/63


Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг даргын нэрэмжит ЕБС-ийн сурагчдын бие бялдрын түвшин тогтоох "Сорил"-ыг зохион байгуулах тухай

Монгол Улсын "Биеийн тамир, спортын тухай" хууль, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 43 дугаар тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2015 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Нийслэлийн Засаг даргын нэрэмжит ЕБС-ийн сурагчдын бие бялдрын түвшин тогтоох "сорил"-ыг 2015 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсугай.
2. Сорил тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 2.420.000 /хоёр сая дөрвөн зуун хорин мянга/ төгрөгийг нийслэлийн орон нутгийн төсвийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн нийтийг хамарсан арга хэмжээний зардлаас гаргахыг нягтлан бодох О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.
4. Тэмцээний бэлтгэл ажлыг урьдчилан хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн С.Саранцэцэгт даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2015 оны сарын . . .-ны өдрийн
А/Б.С. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт




ЕБС-ийн сурагчдын бие бялдрын түвшин тогтоох
“Сорил”-ыг зохион байгуулах төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Оролцогчдын шагнал: 2 x 100.000 төг = 200.000 төг 2 x 80.000 төг = 160.000 төг 4 x 60.000 төг = 240.000 төг	600.000
2.	Байгууллагын шагнал:	1.000.000
3.	Шүүгчдийн ажлын хөлс: /5 хүн x 2 өдөр x 20.000 төг/	200.000
4.	Заал талбайн хөлс	200.000
5.	Анонс,/урилга/	120.000
6.	Цом, өргөмжлөл	300.000
	ДҮН:	2.420.000

Боловсруулсан
Хянасан

А.Болдмаа
О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2015 оны . . . *11 дугаар* сарын *19*-ны өдрийн
А/БЗ дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ЕБС-ийн сурагчдын бие бялдрын түвшин тогтоох
“Сорил”-ыг зохион байгуулах
шүүгчдийн бүрэлдэхүүн

- | | | |
|----|--------------|-------|
| 1. | Ж.Ганболд | шүүгч |
| 2. | А.Болдмаа | шүүгч |
| 3. | Л.Алтанцэцэг | шүүгч |
| 4. | Ш.Долгор | шүүгч |
| 5. | Ц.Март | шүүгч |